

## Орчуулга

2020 оны 4-р сарын 16

Хэнд: Ерөнхий эрх мэдэлтэн, ерөнхий албан тушаалтан, бүсийн дал; гадас, номлол, дүүргийн болон ариун сүмийн ерөнхийлөгч; бишоп, салбарын ерөнхийлөгчид

Хүндэт ах, эгч нар аа,

### Хүнд бэрх цаг үед баримтлах зарчмууд

COVID-19 цар тахалтай холбоотойгоор үндэсний болон муж, орон нутгийн удирдагчдын гаргасан удирдамжийг анхааралтай дагаж мөрдөхөд гаргаж буй та нарын хүчин чармайлтад бид талархаж байна. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм мөн адил зохих урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хэрэгцээтэй хүмүүст тусламж үзүүлсээр байгаа.

Одоогийн болон ирээдүйд үүсэж болох нөхцөл байдалд Сүм ба Сүмийн гишүүд сайн иргэн, сайн хөрш байх үүргээ үнэнчээр гүйцэтгэж харуулна.

Энэхүү захидалд хүнд бэрх цаг үед Сүмийн баримтлах удирдлагын зарчмуудыг тайлбарласан баримт бичиг багтсан. Удирдагчид амин чухал ёслол, адислалууд болон Сүмийн үйл ажиллагааг өнөөгийн хямралтай өдрүүдэд мөн ирээдүйд учирч болох хүнд бэрх өдрүүдэд явуулахад зориулсан удирдамж, зааврыг оруулсан болно.

Дэлхий даяарх COVID-19 цар тахлын улмаас Сүмийн үйл явц болон гишүүдийн үйл ажиллагаа тасалдаж байгаагийн хариуд эдгээр баримт бичгийг гаргав. Тухайн улс оронд эсвэл улс орны газар нутгийн аль нэгэн хэсэгт энэ цар тахалтай холбоотойгоор Сүмийн цуглаанд төдийгүй олон нийтийн газруудад албан ёсны хөл хорио тавигдсан байгаа цагт эдгээр баримт бичгийг удирдамж, заавар болгон ашиглах юм. Шаардлагатай бол өөр бусад удирдамж, зааврыг хожим нэмж гаргана.

Хүндэтгэсэн,

Тэргүүн зөвлөл

# **ХҮНД БЭРХ ЦАГ ҮЕД БАРИМТЛАХ**

## **УДИРДЛАГЫН ЗАРЧМУУД**

2020 оны 4-р сарын 16

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь гишүүдэд мөнх амьдрал өөд хөгжин дэвших явцад нь туслах тэнгэрлэгээр тохоогдсон үүрэг хариуцлагад анхаарлаа төвлөрүүлдэг. Энэхүү тэнгэрлэг зорилгод хүрэхэд нь туслахын тулд Сүм ба Сүмийн удирдагчид санваарын эрх мэдэл, түлхүүр, гэрээ, ёслолуудаар болон бошиглолын удирдамж, заавраар хангадаг. Сүм Есүс Христэд ирж, Түүний зарлигуудыг үнэнчээр сахихад бүх хүнийг урьдаг.

### **Хүнд бэрх цаг үе**

Энэ эрин үед бид хүнд бэрх цаг үеийг туулах болно хэмээн сударт тодорхой өгүүлсэн. Хүнд бэрх нөхцөл байдалд Сүм үндсэн зарчмуудыг тунхаглаж, Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг адислахад шаардагдах ёслолуудыг гүйцэтгэдэг. Цаг хугацаа, нөхцөл байдал ямар байхаас үл хамааран Их Эзэний Сүмийн хувьд зарим зүйл амин чухал хэвээр байдаг. Эдгээрт ариун нандин сургаал, ёслолууд багтана.

### **Дэлхийн иргэний хувьд хүлээх хариуцлага**

Шашны эрх чөлөөг хамгаалж, ухамсрын ариун нандин эрх чөлөөг хүндэлдэг хууль дүрэм олон улс оронд байдагт Сүмийн гишүүд

талархдаг.

Сүм өөрсдийн оршин суудаг газрын хуулийг дэмжин, дагахыг гишүүддээ заадаг. Эдгээр засгийн газар нь олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад хамгийн тохиромжтой гэж үзсэн хуулиудыг өөрсдөө гарган, хэрэгжүүлдэг юм. Онцгой нөхцөл байдалд нийтийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд хувь хүний эрхийг түр хугацаагаар хязгаарлаж болно гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна.

Цар тахлын эсвэл байгалийн гамшгийн үеэр Сүм хурал цуглааныг хойшлуулах, цуцлах зэрэг байдлаар шаардлагатай арга хэмжээнүүдийг авах албан ёсны тушаалыг дагаж, хариу арга хэмжээ авна. Сүм ба Сүмийн гишүүд сайн иргэд, сайн хөрш байхыг эрмэлздэг. Сүм тусламж хэрэгтэй хүмүүст тусламж дэмжлэг үзүүлдэг урт түүхтэй.

Бид дэлхийн сайн иргэд байх амлалт үүргийнхээ хажуугаар өөрийн шашны үндсэн зан үйлд оролцохыг эрмэлздэг сүсэг бишрэлтэй бүх хүнд оролцох нөхцөл, боломж бололцоог олгосон байх ёстойг хүндэтгэлтэйгээр мэдэгдэж байна.

## **Их Эзэн Өөрийн Сүмийг бэлтгэсэн**

Он жилүүдийн явцад хүлээн авсан сүнслэг өдөөлт нь Их Эзэний Сүмийг болон Сүмийн гишүүдийг материаллаг, сүнслэг байдлын хувьд өөрчлөгдөж буй хүнд бэрх цаг үед бэлтгэсэн юм.

Мөн Сүмийн гишүүдэд гэр орондоо хоол хүнсний нөөцтэй байхыг

олон жил зөвлөсөөр ирсэн. Тэд Хүндэтгэлийн өдрийг сахиж, бусдад тохинуулан, Мелкизедек санваарын чуулгуудыг болон Халамжийн нийгэмлэгийг хүчирхэгжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлдэг. Их Эзэн Өөрийн бошиглогчдоор дамжуулан, гэрт төвлөрч, Сүмээс дэмжсэн сайн мэдээнээс суралцаж, үүний дагуу амьдрах хөтөлбөрүүдэд анхаарлаа улам их хандуулах болсон билээ. Гэр орноо хүүхэд, өсвөр үеийнхэнд сайн мэдээг заадаг, итгэлийн өргөө болгоход гишүүдийг урамшуулдаг. *Ирээд, Намайг дага* сургалтын хөтөлбөр нь дэлхийн өнцөг булан бүрд байх гишүүдэд гэр орондоо болон Сүм дээр сайн мэдээнээс суралцах загварыг гаргаж өгдөг. Хүүхэд, өсвөр үеийнхний хөтөлбөр нь мөн л гэр оронд төвлөрсөн байдаг ба үр хүүхдүүдээ сүнслэг байдал, оюун ухаан, бие махбод, нийгмийн харилцааны хувьд сурган хүмүүжүүлэх боломжийг эцэг эхчүүдэд олгодог.

Гишүүдийг энгийн бөгөөд бодит байдлаар сайн мэдээний захиасыг техник технологи ашиглан хуваалцахад урамшуулдаг. Нүүр тулан уулзах боломжгүй байсан ч хүмүүсийг олж, тэдэнд заах боломж олгох техник хэрэгслээр номлогчдыг хангасан. Гишүүд гэр бүлийн түүхийн ажилд гэр орноосоо оролцож болно.

Бид эдгээр болон өөр бусад хичээл зүтгэл хоорондоо хэрхэн уялдан холбогдож байгаа загварыг харахдаа Их Эзэн хүнд бэрх цаг үед биднийг хэрхэн зохион байгуулалттай, дэс дараалалтай бэлдсэнийг олж хардаг.

### **Үндсэн зарчим, ёслолууд**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол дэг журмын Сүм. Ёслол, адислалууд бол санваарын эрх мэдлээр өгөгддөг ариун

нандин зан үйлүүд юм. Зарим үйл явц нөхцөл байдлаас үүдэн өөрчлөгдөж болох ч үндсэн сургаал, зарчим, ёслолуудыг хамгаалах нь зүйтэй.

Гишүүнээр батлах, томилох, адислах, онцгойлон адислах, санваарын түлхүүрийг өгөх гэх мэт олон ёслолыг толгой дээр гар тавин өгөх шаардлагатай байдаг. Ийм ёслолуудыг үйлдэхэд ёслол гүйцэтгэж байгаа санваартан хүлээн авч байгаа хүнтэй нэг дор байх шаардлагатай. Санваарын ёслолуудыг технологи ашиглан зайнаас үйлдэж болохгүй. Шаардлагатай нөхцөл байдал үүсэх үед, удирдах эрх мэдэлтэн зөвшөөрсөн тохиолдолд өөр хүмүүс ёслолыг технологиор дамжуулан үзэж болно.

Энэхүү хүнд бэрх цаг үед удирдах эрх мэдэлтнүүд аль ёслолыг түр хугацаагаар хойшлуулахаа мэргэн ухаанаар шийдэх нь зүйтэй. Халдварт өвчин гарсан нөхцөлд ёслолуудыг гүйцэтгэх хүмүүс өөрсдийгөө болон бусдыг хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээнүүдийг авсан байх ёстой.

Сүмийн чухал ёслол, адислал болон бусад үйл ажиллагааны талаарх удирдамжийг хавсаргав.

Дэлхий даяарх КОВИД-19 цар тахлын улмаас Сүмийн үйл явц болон гишүүдийн үйл ажиллагаа тасалдаж байгаагийн хариуд эдгээр баримт бичгийг гаргав. Тухайн улс оронд эсвэл улс орны газар нутгийн аль нэгэн хэсэгт энэ цар тахал, үүнтэй холбоотой Сүмийн цуглаанд болон олон нийтийн албан ёсны хөл хорио тавигдсан байгаа

цагт эдгээр баримтыг удирдамж заавар болгон ашиглана. Өөр бусад удирдамж зааврыг хожим нэмж гаргах магадлалтай.

## Дүгнэлт

Бошиглогч Нифайн хэлсэнчлэн, “Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлиг эс буулгана” (1 Нифай 3:7). Их Эзэн бидэнд тусална. Санваарын хүч болон гишүүдийн зөв шударга байдал ирэх өдрүүдэд урагшлахад бидэнд туслах болно.

# ШААРДЛАГАТАЙ ЁСЛОЛ, АДИСЛАЛ БОЛОН СҮМИЙН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗОРИУЛСАН УДИРДАМЖ

2020 оны 4-р сарын 16

Онцгой тохиолдолд, шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа үед ёслолуудыг ихэнхдээ гүйцэтгэж болдог. Тухайлбал, халдварт өвчин сэтгэл түгшээх үед ёслолуудыг гүйцэтгэж буй хүмүүс гараа сайтар угаах хэрэгтэй төдийгүй бээлий, нүүрний маск хэрэглэж болно.

## **Баптисм ба гишүүний баталгаа**

Баптисм хүртэх, гишүүнээр батлахад зохих түлхүүрүүдийг атгаж буй санваарын удирдагчийн зөвшөөрөл шаардлагатай. Шаардлагатай бол баптисмын үйлчлэлийг баптисмд нэр дэвшигч, баптисмыг гүйцэтгэх прист юм уу Мелкизедек санваартан мөн хоёр гэрч гээд дөрвөн хүнтэй цөөхүүлээ гүйцэтгэж болно. Баптисмыг шаардлагатай санваарын түлхүүрүүдийг атгадаг бишопын юм уу номлолын ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Бишоп юм уу номлолын ерөнхийлөгч эсвэл тэдний томилсон хүн (гэрчүүдийн нэг нь байж болно) баптисм ба гишүүний баталгааг ажиглаж, бүртгэх ёстой. Шаардлага гарвал, зөвшөөрөл олгосон хүн үүнийг технологи ашиглан, зайнаас гүйцэтгэж болно. Удирдагчид, гэр бүл болон найз нөхөд нь технологи ашиглан, зайнаас ажиглаж болно. Ариун ёслолын цуглаануудыг түр хугацаагаар зогсоосон тохиолдолд хөрвөгчдийг баптисм хүртсэн даруйд баталж болно.

## **Санваарын томилгоо ба онцгойлон адислал**

Санваарын томилгоо, онцгойлон адислалд зохих санваарын түлхүүрийг атгагч хүнээс урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай байдаг. Бас эрх мэдэл бүхий санваар атгагч гар тавих шаардлагатай. Ёслолыг санваарын түлхүүрүүдийг атгагч эсвэл түүний томилсон хүн ажиглаж, бүртгэх ёстой. Шаардлагатай бол, энэ хүн ёслолыг технологи ашиглан, зайнаас ажиглаж болно. Удирдагчид, гэр бүл, найз нөхөд нь технологи ашиглан, зайнаас ажиглаж болно.

Томилгоо, дуудлага, онцгойлон адислахыг зохих санваарын түлхүүрүүдийг эзэмшигч урьдчилан баталсан тохиолдолд гадасны болон тойргийн хэмжээнд дэмжүүлэн батлуулалгүй гүйцэтгэж болно. Энэ нь Их Эзэний ажлыг урагшлуулах боломжийг олгоод зогсохгүй, цуглаан дахин явагдаж эхлэх үед дараа баталгаажуулж болно.

## **Өвчтөнийг адислах**

Санваарын адислал өгөхөд гар тавих шаардлагатай болдог. Энгийн үед хоёр ба түүнээс дээш тооны Мелкизедек санваар атгагч адислал өгдөг байсан бол харин одоо нэг хүн адисалж болно. Шаардлагатай урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авсны дараа нөхцөл байдлаас шалтгаалан хүний толгой дээр гар тавьж болохгүй нөхцөлд мөн технологи ашиглан, залбирал хэлж болно. Энэ нь санваарын адислал бус, итгэлийн залбирал болдог. Хэн ч хэзээ ч залбирч, мацаг барьж эсвэл өөр ямар нэгэн арга замаар бусдад тохинуулах боломжтой.



## Ариун ёслол гүйцэтгэх

Гишүүд боломжтой бол ариун ёслолын цуглаанд оролцон, долоо хоног бүр ариун ёслолоос хүртэх адислалаа ашигладаг байвал нэн сайн. Онцгой нөхцөлд, тойргийн ариун ёслолын цуглаан удаан хугацаанд хийгдээгүй тохиолдолд бишоп тойргийнхоо зохистой санваартнуудад өөрсдийн гэр оронд эсвэл гэрт зохистой прист эсвэл Мелкизедек санваар атгагчгүй айлд ариун ёслолыг бэлтгэн, гүйцэтгэх зөвшөөрөл олгодог (*General Handbook*, 18.9.1-ийг үзнэ үү). Шаардлагатай үед ариун ёслолыг прист эсвэл Мелкизедек санваар атгагч дангаараа гүйцэтгэж болно.

Гишүүд талх, усаа өөрсдөө гаргаж болох ч ариун ёслолыг эрх мэдэл бүхий санваар атгагч (санваар атгагч нар) бэлтгэх ёстой. Ариун ёслол гүйцэтгэж буй санваар атгагч (санваар атгагч нар) талхыг хуваан, залбирал хэлж, бэлгэдлийг түгээхдээ ариун ёслол хүртэж буй хүмүүстэй нэг газарт байх ёстой. Ариун ёслол гүйцэтгэх боломжгүй онцгой нөхцөл байдалд гишүүд ариун ёслолын залбирлаа судалж, байгуулсан гэрээнүүдийнхээ дагуу амьдрахаар дахин амлалт өгч, санваарын зохих ёсоор гүйцэтгэсэн ариун ёслолоос хүртэх тэр нэгэн өдрийн төлөө залбирч, тайтгарал хүлээн авч болно. Хувь хүн болон гэр бүлүүд өөрийн биеэр эсвэл зайнаас хувиараа, гэрт төвлөрсөн Хүндэтгэлийн өдрийн шүтлэг бишрэлийн үйлчлэлээ хийх үедээ адислагдаж байдаг. Ийм шүтлэг бишрэлд залбирал, сүмийн дуулал, сайн мэдээ судлах зэрэг нь орно. Санваар атгагч (санваар атгагч нар) байгаа болон зөвшөөрөгдсөн газарт ариун ёслолыг адисалж, түгээж болно.

## **Сүмийн бусад үйл ажиллагаа**

**Цуглаан.** Нэн онцгой тохиолдолд удирдагчид цуглаан, үйл ажиллагаануудыг түр хугацаагаар зогсоож болно. Нөхцөл байдлаас шалтгаалан бишопын зөвлөлийн хурал, ярилцлага, тойргийн зөвлөлийн хурлуудыг утас болон видео дуудлага зэрэг технологийг ашиглан, зайнаас явуулж болно. Бишоп, тойргийн удирдагчид аль нэг гишүүний гэрт төвлөрсөн шүтлэг бишрэлийг дэмжихийн тулд технологи ашиглан, захиас хуваалцаж болно.

**Тохинуулал.** Тохинуулагч ах, эгч нар томилогдсон хувь хүнийг болон гэр бүлийг шаардлагатай дэмжлэг туслалцаагаар хангах олон арга зам байдгийг мэдэж авах болно. Тохинууллыг очиж эсвэл технологи ашиглан, зайнаас явуулах эсэх нь орон нутгийн нөхцөл байдал, холбогдох хүмүүсийн хэрэгцээ, хүсэл, эрүүл мэнд зэргээс шалтгаална. Тохинууллын ярилцлагыг шаардлага гарсан үед технологи ашиглан, зайнаас хийж болно. Биеийн болон сэтгэцийн эсвэл сэтгэл санааны ноцтой бөгөөд яаралтай хэрэгцээ гарах нэн онцгой нөхцөлд л биеэр очиж тохинуулна. Тохинуулагч ах, эгч нар зөв зохистой арга замаар хайр, дэмжлэгээ харуулах нь зүйтэй.